

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ДҮҮРГИЙН УДИРДЛАГУУД БОЛОН АЛБАН ТУШААЛТНУУДЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

2018 оны 06 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Сард 2 удаа Засаг дарга болон дүүргийн удирдлагууд иргэд хүлээн авах уулзалтыг зохион байгуулж, уг уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийг дуустал Засаг дарга нийт 126 иргэнийг хүлээн авч уулзаж, тэдний өргөдөл хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэн, судалж үзэн шийдвэрлэх шаардлагатай бичгээр хандсан өргөдөл, хүсэлтийг өргөдөл гомдлын нэгдсэн программд бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэн иргэдэд холбогдох хариуг өгч ажилласан.



Уулзалтаар 56 буюу 41,2 %- нь АОС хөтөлбөрт хамрагдах, эмчилгээний мөнгөн тусламж буюу шагнал урамшуулалд хамрагдах хүсэлт, 15 буюу 18,9 %-нь газрын асуудлаар хамгийн их хандсан байна.

Дахин төлөвлөлтөд орж байгаа орон сууцны оршин суугчид болон аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийн дагуу дүүргийн 1, 3, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 7, 8, 9, 10, 11, 12, 22, 23, 24, 37, 35, 36 дугаар барилгыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын төслийн явцтай танилцах уулзалт хурлыг сууц өмчлөгч иргэдийн саналын дагуу 2018 оны 06 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд 1, 3, 4 дүгээр хорооны Иргэний танхимд зохион байгуулсан.

Иргэдийн хүсэлтийн дагуу зөвшөөрөлгүй байршуулсан 45 гаруй ТҮЦ контейнерыг нүүлгэн шилжүүлсэн.



Иргэдтэй хийж байгаа уулзалтын мэдээг сар бүр www.bgd.mn цахим хуудсаар мэдээлж ажилласан.